

2024 оны 09-р сарын 20-ны өдөр

Дугаар№1

Улаанбаатар хот

**Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
ЦДҮС ТӨХК-ын Улаанбаатар салбарын конторын барилгын гадна фасадны
засварын ажлын даалгавар**

Тус конторын барилга тэнхлэгээрээ 31х13м хэмжээтэй шугаман суурьтай 510 мм зузаан тоосгон ханатай 3 давхар конторын зориулалтай барилга юм. Засварын ажлаар гадна хөөсөнцөо фасад хийх, галын аваарын шат буулгах, шинээр дээвэр рүү гардаг шат хийх барилгын нэр хаяг хийх гадна орчны тохижилтын ажил хийхээр төлөвлөгдсөн. Гадна фасадны талбайн нь S=1162м²

1. Хөөсөн полистрол фасаданд тавигдах шаардлага

Ханын гадаргуугийн зай завсрыг сайтар битүүмжлэн цэвэрлэж, хатааж бэлдэнэ;

1.1 Бетон болон тоосгон ханын гадаргууд байх чийгшлийн зөвшөөрөгдөх хэмжээ нь 4% байна.

1.2 Дулаалгын хавтан хоорондын завсар зайны зөвшөөрөгдсөн хэмжээ нь 2 мм-ээс ихгүй байна.

1.3 Хавтан хоорондын зайг шавраар бөглөхийг хориглох бөгөөд зайг холбогдох чанар стандартын шаардлага хангасан шахдаг хөөсөөр бөглөнө.

1.4. Дулаалгын хөөсөнцөр полистрол хавтан нь MNS EN 13163:2011 "Барилгын дулаан тусгаарлах материал Хөөсөн полистрол (EPS) бүтээгдэхүүн. Техникийн шаардлага", тохирлын гэрчилгээтэй байна.

1.5. Гадна ханын дулаалгын ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд: - гадна ханын гадаргууг сайтар битүүмжилж, цэвэрлэж хөрсжүүлэх; - 3-4мм зузаан цавуулаг хольц (хар замаск) ашиглан хөөсөнцөр хавтанг наана - хөөсөнцөр хавтангийн зузаанаас хамаарч тэлэгчтэй шрүпийн уртыг тохируулан, хавтанг найдвартай хийцэд тогтооно; - тэлэгчийн тавыг далдалж шавардана - тор ашиглан 1-2 үетэй шавардлага хийх. Хөрсжүүлэгч /грунт/ хийсний дараа өнгө эмульс хийнэ.

1.6. Хөөсөнцөр хавтангийн нягт 23-25кг/м³ байна. Нягт, хэмжээнээс хамааран 0.5м² -1м² талбайд 5-7 тэлэгчээр тогтооно.

1.7. Хуванцар тэлэгчийн тав тогтоох явцад хэв гажилтад шрүпний толгой мултрахгүй байх бөгөөд толгой нь хавтангийн гадаргуутай нэг түвшинд байна.

1.8. Хөөсөнцөр хавтанг тогтоохдоо тэлэгч, шрүпний толгойг хавтангийн гадаргуугаас 1мм-ээс илүү гаргахгүй, ашиглалтын шаардлагаар тэлэгч шрүп ашиглана.

1.9. Угсралтыг хийхдээ заавал цавуут зуурмаг ашигладаг тул гадна агаарын температур +5°C-аас +30°C үед хийнэ. +5°C-аас доош температурт хийх тохиолдолд зуурмаг болон эмульсийг хөлдөөхгүй, шатны гадуур хучлага хийж +5°C дээш температурд бариулах буюу хүйтний нөхцөлд заслын ажил гүйцэтгэх БНБД, стандартыг баримтална.

1.10. Хавтангийн зузааны ялгаа нь ±3 мм-ээс хэтэрч болохгүй.

1.11. Цонхны амалгааны 2 хажуу, дээд хэсгийг цонхны рамын өргөнөөс хамааран 15-30мм зузаантай хөөсөнцрөөр ам даруулж наана.

1.12. Барилгын гадна талын дулаан тусгаарлалтыг газрын түвшингээс 0,65-0,7м өндрөөс эхлэн хийнэ. материал нь гаднаас ирэх ачаалал /даралт/ даах, ус чийгэнд тэсвэртэй материалаар сонгож, шавардана.

1.13. Ажил гүйцэтгэх үед +5°C буюу түүнээс дээш температуртай салхигүй нөхцөлд люлк ашиглаж болно. Бусад үед зориулалтын шат тавцан ашиглана. Ажилтан бүр хувийн хамгаалах хэрэгсэл (каска, бээлий, өндрийн бүс) хэрэглэнэ.

1.14. Ажил гүйцэтгэгч нь өдөр бүр ажил дууссаны дараа ажын талбайг цэвэрлэж, хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт хаях.

1.15. Бараа материалыг бусдын хөдөлгөөнд саад болохгүй эмх цэгцтэй, төвлөрсөн цэгт хураах.

2. ХАЯАВЧ

Барилгын хаяавчийг М150 маркийн бетоноор цутгаж, бетон арчилгааг норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын хаяавчийг хийхийн өмнө газрыг тэгшилж сул шороог доргиураар нягтруулж өгнө. Хаяавчны өргөн 1000мм, зузаан 100-150мм.

Барилгын цоколийн ханыг боржин хавтангаар хана өнгөлөх. 103м2

3.Борооны ус зайлуулах систем

Дээвэрт байрлах ховооны гадна амсар нь дээврийн налуу дагаж буух шулуун угсралтын түвшинд байрласан байна. Ховооны гадна ирмэн, дээврийн доод үзүүрээс холдох хэмжээ нь өөрийнх нь хоёр амсар хоорондын зайны 50% буюу 75-80 мм байна. Барилгын урд, болон хойд хэсгээр ф100мм яндан хоолой 3-4 хэсэгт буулгах, Ховоог 50-70см, хоолойг 2м тутамд нэг тогтоогчоор тогтооно.

4. Бусад ажил

Цонхны амалгаа, парапетын малгай төмөрт гадна фасадны зузаанаар 0.5-0.8мм зузаантай гөлмөн төмрөөр хийж завсар зайг силконоор хийж өгөх. Бусад ирмэгийг сайн чанарын шавараар тор тавьж шавардах.

Барилгын гадна байралсан Эйр кондешн буулган гадна фасад хийсний дараагаар нэг түвшинд байрлуулан буцаан холбох.

Барилгын гадна талаар явж байгаа цахилгаан болон холбоо камерын утаснуудыг хамгаалалт хийж фасадны цаана хийж угсрах

Барилгын зүүн талд байгаа аваарын шат буулган авах

Барилгын баруун талд дээвэр рүү гарах шат галын дүрмийн дагуу хийж өгөх.

Барилгын дээвэр дээр байгаа хаяг бичлэг шинээр хийх / одоо байгаа хэмжээнээс багасахгүйгээр /

Барилгын гадна фасадны өнгийг хажуугийн барилгын өнгөтэй адилхан болгох

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

УБС БАЙРНЫ ГАДНА ЗАСЛЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гадна хананд гал дэмждэггүй 10 см хөөсөн хавтангаар фасад хийх	м2	1162.75
2	Фасадны чулуут шавардлага хийх	м2	1162.25
3	Гадна хана усан эмүльсэн будгаар гар аргаар будах	м2	1162.25
4	2м2 хүртэл талбайтай хуучин хаалга буулгах шинээр бүргэд хаалга суулгах	ш	1
5	Байрны дээгүүр товгор хүрээ хийж шавардах	у/м	87.2
6	Цонхны гадна талаар гоёлийн хүрээ хийж шавардах	у/м	302.4
7	18 м хүртэл өндөр дүүжин шат угсрах ба задлах	м2	414.5
8	Аваарийн төмөр шат буулгах	тн	3.5
9	Дээвэрт гарах шат угсрах	тн	1.5
10	Барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлуулах хоолойн хамт хийх	м	93.4
11	Барималын арилгахад хялбар хог хаягдал толбыг цэвэрлэх арилгах	1м2	1162.75
12	Агаар хөргөгч буулгах	ш	10
13	Агаар хөргөгч суурилуулах	ш	10
14	Барилгын гадна талын ус зайлуулах хоолойн хамт хийх	м2	1162
15	Барилгын гадна цонхны талын төмөр эдлэлүүд ус зайлуулах хийх	м2	48
16	Барилгын хананд салбарын нэр хаяг хийх	ком	1
17	Бетон хаяавч хийх	м3	15.5
18	1 м2 д 2 хүртэл ширхэг өнгөлсөн боржигон хавтангаар хана өнгөлөх	м2	91.5
19	Барилгын бусад жижиг ажиллууд	и/б	10

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь

1. Барилгын засварын ажлыг батлагдсан ажлын даалгавар, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.

4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.

5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.

6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

7. Барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

8. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.

9. Хэрэв материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

12. Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т /14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-д /14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар

ХЯНАСАН:

УЛААНБААТАР САЛБАРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Б.БАЯРМАНДАХ

БОЛОВСРУУЛСАН:

ЗУРАГ ТӨСВИЙН ИНЖЕНЕР



Б. ТҮМЭНБАЯР

БАРИЛГЫН ИНЖЕНЕР

Б.ХОНГОР